

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2023.04.20

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2023/1/НА-СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймгийн засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэс
Аудитын нэр:	“Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Санхүүгийн аудитын алба

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай зарцуулсан эсэх.

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн зохицуулалт хийсэн судалгаа, мэдээлэл болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт: Орон нутгийн 2022 оны төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Хариулт 1: Орлогыг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 8 нэр төрлийн орлогыг бууруулж баталсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөөгүй байна.

Гол асуулт / аудитын дэд зорилт: Орон нутгийн 2022 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?

Хариулт 2: *Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.*

2.2.3 Гол асуулт / аудитын дэд зорилт: Орон нутгийн 2021 оны төсвийн зарлагыг бодитой төлөвлөсөн үү?

Хариулт 3: *Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Орон нутгийн сан”-гийн журмыг бүртгээгүй байхад 1,000.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан нь урсгал зардлыг бодит тооцоололд үндэслэн төлөвлөөгүй байна.*

2.2.4 Гол асуулт / аудитын дэд зорилт: Орон нутгийн төсвийг үр ашигтай зарцуулсан байна уу?

Хариулт 4: *Төсвийн гүйцэтгэл 80.6 хувьтай, яамдтай байгуулсан гэрээ 92.9 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн нь төсвийн үр ашиг хангалттай байгааг харуулж байна.*

2.2.5 Гол асуулт / аудитын дэд зорилт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй зарцуулсан уу?

Хариулт 5: *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 288.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.*

2.2.6 Гол асуулт / аудитын дэд зорилт: Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулсан уу?

Хариулт 6: *Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.*

Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс				Үр өгөөжийн	
			Дээд газарт санал хүргүүлэх	Залруулсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй.	-	-					
2	2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос урьдчилан	303.3	303.3					

	олгосон орлогыг Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэсэн боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнасан.							
3	Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн ч орлогын нэр төрлөөр тасарсан, зарим сумд төлөвлөгөө тасалсан байна.						-	
4	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан төсвийн орлого, зарлагыг бууруулан зохицуулалт хийсэн.	845.5			845.5			
5	Өмнөх оны аудитаар боловсролын байгууллагуудын тогтмол зардалтай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжээгүй, одоог хүртэл дотуур байрны халах талбайн хэмжээ маргаантай мөн халаалтын үнэ тарифыг төсвийн жилийн дундуур нэмдэг асуудлууд илэрсээр байна.						-	
6	Төсөв захирагч нарын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн нийт 288.7 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илэрсэн						-	
7	Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг илүү тайлагнасан	167.3		167.3				
Дүн		1,316.1	303.3	167.3	845.5	-		

Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Албан тушаал овог нэр:

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

Анхан шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:

АХЛАХ АУДИТОР

Т.БАТСАЙХАН

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

Танилцаж зөвшөөрсөн: Албан тушаал овог нэр:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ